

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 2 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.03.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн өргөтгөсөн хурлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, сумдын Засаг дарга нарыг хамруулан цахим хэлбэрээр зохион байгууллаа. Хурлаар аймгаас 2020 оныг "Иргэний хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна сум, байгууллагын онцлогт тохирсон ажлын төлөвлөгөө гарган ажиллах, сумын Засаг даргаас аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх талаар чиглэл өгч, хууль хяналт, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн салбар, газрын харилцаа, мэргэжлийн хяналт, Улсын бүртгэлийн чиглэлээр 2020 онд хэрэгжүүлэх бодлогын зорилтуудыг танилцуулж, анхаарах асуудлын талаар мэдээлэл өглөө.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон дэлхийн бусад оронд коронавируст /COVID-19/-ийн халдвар гарч, хил дамжин халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор аймгийн Онцгой комиссын шуурхай хурлыг сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг оролцуулан цахим хэлбэрээр зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын албан даалгавар, захирамжийн заалт бүрийг орон нутгийнхаа нутаг дэвсгэрт бүрэн хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болголоо.

Аймгийн Онцгой комиссоос Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн "Заавар батлах тухай" А/577 тоот тушаал, МХЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн "Заавар батлах тухай" А/192 тоот тушаал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 хурлын тэмдэглэл, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, МХЕГ-ын даргын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/28 тоот тушаалын дагуу Аймгийн Засаг даргын 2020 оны А/16, А/56, А/57, А/58, А/66, А/68, А/69 нийт 7 захирамж гарган аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу шинэ төрлийн коронавирусийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн нутаг дэвсгэрт эрчимжүүлэх, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол аймгийн Засаг даргын албан даалгавар, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих, сумдын бэлэн байдлыг шалгаж заавар зөвлөмж өгөх чиглэлээр 7 ажлын хэсэг нийт сумдад 2020 оны 02 дугаар сарын 18-наас 20-ны өдрүүдэд ажилласан.

2020 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Сэлэнгэ аймагт нийт Монгол улсын 80 иргэн ажиглалтад байгаагаас аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт 13 иргэнийг ажиглалтанд 3 иргэнийг сэжигтэй тохиолдлоор, 64 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг, Сүхбаатар сумын хилийн боомтын түр тусгаарлах байруудад тусгаарлаж эмчийн хяналтад аваад байна. Үүнд: Алтанбулаг чөлөөт бүсийн ажиглалтын А байранд 8, ажиглалтын Б байранд 18, Алтанбулаг сумын Нийгмийн даатгалын ажиглалтын байранд 6, Сүхбаатар сумын Хүлэг зочид буудлын ажиглалтын байранд 4, Сүхбаатар сумын ахмадын сувилалын

ажиглалтын байранд 17, УБТЗ-ийн Сүхбаатар өртөөнд 11 иргэн байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт тусгаарлагдсан 16 иргэнээс 3 удаагийн давтамжтай 16 сорьцийг УБ хотын Халдварт өвчин судлалын үндэсний төвийн томуугийн лабораторит хүргүүлсэн. Үүнээс 13 сорьцийн хариу сөрөг гарсан, бусад сорьцийн хариу гараагүй байна.

Улсын Онцгой комиссын гишүүн, МХЕГ-ын дарга Н.Цагаанхүүгээр ахлуулсан ажлын хэсэг манай аймагт 3-р сарын 1-ээс ажиллаж байна.

Ковид-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Алтанбулаг, Сүхбаатар боомт дээр аймгийн Хилийн мэргэжлийн хяналтын албаны 32, ЭМГ, нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг сумын хязгаарлах байруудад 64 эмч, сувилагч, ариутгагч, жолооч 24 цагаар байнгын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байна.

Иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор 15 чиглэлд Цагдаагийн байгууллагаас 24 албан хаагч, Онцгой байдлын байгууллагаас 9 албан хаагч, Эрүүл мэндийн байгууллагаас 8, Мэргэжлийн хяналтын газраас 1 албан хаагч, бусад төр төсвийн байгууллагын 21, нийт 62 албан хаагч, 15 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.

Хилийн боомт, Алтанбулаг сумаар дайран өнгөрч буй Олон улсын чанартай авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийг ариутгах ариутгал халдваргүйтгэлийн ПУНКТ байгуулж, “Уураар мананцар үүсгэгч төхөөрөмж”-өөр тоноглон орох гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудаас тухай бүр өгч байгаа мэдээ мэдээлэл, батлагдсан зөвлөмж сэрэмжлүүлэг, коронавируст /COVID-2019/-н халдвараас урьдчилан сэргийлэх болон өвчлөлийн талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг аймгийн болон албаны фэйсбүүк пэйж хуудас болон веб сайтад 2020 оны 02 сарын 14-ны өдрөөс 03-р сарын 01-ний өдрүүдэд нийт 18 удаа нийтэлж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 оны байдлаар 96.34, 2016-2020 оны байдлаар 93.09 хувьтайгаар тайлагналаа.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тухайн жилээр буюу 2019 оны байдлаар 93.1, 2016-2020 оны байдлаар 90.4 хувьтай байна.

Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХАСХОМэдүүлэг гаргах 274 албан тушаалтнуудын 2019 оны ХАСХОМэдүүлэгийг 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргуулж хуулийн хэрэгжилтийг хангаж мэдүүлэг гаргагч нарын ХАСХОМ-ийг хүлээн авч бүртгэн тайланг Авлигатай тэмцэх газрын Хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүллээ. ХАСХОМ-гээ хоцроосон болон татгалзсан албан хаагч байхгүй байна.

Улсын тэргүүний сум шалгаруулах Төвийн бүсийн аймгуудын зөвлөлийн хуралд Сэлэнгэ аймгаас Сайхан сумыг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэн Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох материалыг хүргүүллээ.

Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран “Монгол түмний мэнд”, ТВ-8 телевизтэй хамтран “Сар шинийн мэнд” нэвтрүүлгүүдийн бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулсан.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Сайхан, Баянгол, Мандал, Сүхбаатар сумын 7 аж ахуйн нэгж, иргэний 7 үйлчилгээний газар, 1 хагас боловсруулсан бүтээгдэхүүний цехийн үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж стандартын шаардлага хангасан 8 иргэн аж ахуйн нэгжид аймгийн орон тооны бус баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр тохирлын гэрчилгээ олгосон.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Сүхбаатар сумын 4-р багт байрлалтай “Эмээгийн талх” талхан цехийн үйлдвэрлэсэн жижиг талх, загасан талх, бор талх, булочка, боорцог, наран боов зэрэг 6 нэр төрлийн талх, нарийн боов, Зүүнбүрэн сумын иргэн Ж.Цэнгэлийн үйлдвэрлэсэн нөөшилсөн өргөст хэмх зэрэг бүтээгдэхүүнийг МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт гаргасан бөгөөд бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлүүлж аргазүйн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Стандартын салбар сан:

Тус сангаас 7 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 4 нэрийн 11 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр “Цемент шохой” ХХК-ий 1 усны тоолуурыг шалгаж, механик хэмжлийн төрлөөр Сүхбаатар сум дахь худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 18 жин, Дулаанхан тосгоны эрүүл мэндийн төвийн 2 жинг шалган баталгаажуулалт хийсэн.Цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын иргэдийн 1 фазын 15 ширхэг тоолуур шалган баталгаажуулсан. Мөн Дулаанхан тосгоны Эрүүл мэндийн төвийн 3 термометр, 2 ширхэг цусны даралтын аппарат, 2 манометр, “Гор ган” ХХК-ий 2 манометрийг шалган баталгаажуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

/1-р сарын байдлаар/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	9.716.566.4	7.799.431.4	80.3
1.1	Орон нутгийн төсвийн орлого	1.946.808.9	1.659.672.1	85.3
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	1.500.523.4	1.332.805.2	88.8
	Сумдын төсвийн орлого	446.285.5	326.866.9	73.2
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1.209.129.9	1.209.129.9	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	4.930.629.4	4.930.629.4	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	406.106.9		
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1.223.891.3		
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/			
1.7	Эрүүл мэндийн даатгалын шилжүүлэг	49.241.7		
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/			
	2. Орон нутгийн төсвийн нийт зарлага	10.214.352.8	3.725.716.1	36.5
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	10.214.352.8	3.725.716.1	36.5
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын	8.409.648.5	2.142.089.6	25.5

	зарлага			
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан			
	Сумдын сум хөгжүүлэх сан			
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	1.804.704.3	1.583.626.5	87.7
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1.005.088.8		
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт			
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	394.328.4		
	Халамжийн сан	8.400.0	2400.0	28.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	1.611.186.8	1.517.926.5	94.2
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	102.351.4		
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	4.809.589.0	2.142.089.6	44.5
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	121.040.4	63.300.0	52.3
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг	4.968.065.1	4.968.065.1	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1.790.727.0	1.790.727.0	100.0
	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	11.778.5		100.0
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	11.778.5		100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд			
	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	394.328.4		
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	394.328.4		
	Усны татаас			
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	4.809.589.0	4.725.005.0	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	121.040.4	66.428.2	100.0
	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	4.930.629.4	4.791.433.2	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	2.605.836.6	2.605.836.6	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	1.544.410.2	1.472.696.3	95.4
	- Эрүүл мэндийн байгууллага	646.472.1	646.472.1	100.0
	- Газрын кадастрын байгууллага	66.428.2	66.428.2	100.0
	- Хүүхдийн байгууллага	67.482.3		
	4. Тусгай сангуудын зарлага			
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан			

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2019 12- сар	2020 01- сар	2020- 01 2019-12 /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
Талх /орон нутгийн, ш/	1 200	1 200	100.0
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			

	Хонины мах /кг/	6 500	7 500	115.4
	Үхрийн мах /кг/	8 300	8 800	106.0
	Адууны мах /кг/	7000	7 500	107.1
	Ямааны мах /кг/	6 000	7 000	116.7
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 800	1 600	88.9
	Сүү / савласан, л/	2 600	2 800	107.7
	Тараг /задгай, л/	2 000	1 800	90.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	15 000	100.0
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 000	100.0
	Лууван /кг/	1200	1 200	100.0
	Манжин /кг/	1200	1500	125.0
	Байцаа /кг/	1500	1200	80.0
	Сонгино /кг/	1500	1800	120.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 200	120.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 750	106.4
	Бензин А - 92	1 725	1 840	106.7
	Дизелийн түлш	2 275	2 470	108.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 1 сард 9 холбогдогчтой 62,6 сая төгрөгийн хохиролтой, 61 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 8 хэргээр буюу 11,5 хувиар буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 5,9 хувьтай байгаа нь өмнөх оноос 1,7 хувиар өссөн байна. 1671 зөрчил илрүүлсэн нь 536 зөрчлөөр буюу 24,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 2 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 262, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 108, лавлагаа 4 олгосон. Иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл 202 /эрэгтэй-105, эмэгтэй-97/, шэрлэлтийн бүртгэл 60, гэрлэлт цуцалсны бүртгэл 13, үрчлэлт 6, эцэг тогтоолт 16, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 9, нас баралт 61, нийт олгосон иргэний үнэмлэх 498, гадаад паспорт олголт 76, ОХУ-ын хил нэвтрэх хавсралт 2310 олгосон. Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 213, хот доторх шилжилт хөдөлгөөн 176 тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн архивын тасгаас баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд аймгийн Барилга угсралтын контор, Сүхбаатар сумын 1 дүгээр сургууль, Сант сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нийт 3 хөмрөгийн 52 хадгаламжийн нэгжийн 6944 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 5958, хүний нэр 33726, газар зүйн нэр 2330, байгууллагын нэр 1906 шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Төрийн архивын AMS программд Сант сумын МСҮТ /татан буугдсан/-ийн 1977-2014 оны 24 ХН-ийн дансны мэдээллийг шивж оруулсан.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар 246, цаасан суурьтай баримтнаас 59, мастер хувиас 53, нийт 358-г тодорхойлолт, магадлагаа 39-г тус тус гаргаж үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаатай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны А/43 тоот “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” тушаалаар 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон. Дээрх хугацаанд боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны байгууллагуудад нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг байгууллагын дарга, захирал даалган хэрэгжүүлж байна. Сургууль, цэцэрлэгүүдийн нөхцөл, байдлын мэдээллийг google.drive-аар 7 хоног бүрийн баасан гарагт мэдээллийг авч байгаа бөгөөд онлайн хурал, уулзалтыг лхагва гараг бүрт зохион байгуулж, мэдээлэл, чиглэл, зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны ерөнхий боловсролын бодлогын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны 4/500 “Тушаал хэрэгжүүлэх тухай” албан тоотоор ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээлийг үндэсний хэмжээнд телевизээр зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу багш нарт телевизээр заасан хичээлийг бататгах, ажил үүргийн зохион байгуулж байна.

2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн боловсролын баримт бичгийн захиалгыг 2020 оны 74 тоотоор БСШУСЯ-ны ерөнхий боловсролын бодлогын газарт хүргүүлсэн. Энэ хичээлийн жилд суурь боловсролын гэрчилгээг 1443, бүрэн дунд боловсролын үнэмлэхийг 1003 төгсөгч авах урьдчилсан судалгаа гарсан. Их, дээд сургууль, коллежид элсэхийг хүсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлийг эхлүүлсэн ба Боловсролын үнэлгээний төвөөс ирүүлсэн зөвлөмж, мэдээллийг сургуулиуддаа хүргүүлэн ажиллаж байна.

БНСУ-ын Койка олон Улсын байгууллагын дунд хугацааны сайн дурын 8 ажилтныг хүлээн авч, 1 жилийн хугацаанд ажиллах төлөвлөгөөг боловсруулан хамтран ажиллаж эхэлсэн.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2020 оны 1 дүгээр сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 625 байсан бол 115 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 46 ажлын байранд 46 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 83 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 611 болсон байна.

Тайлант хугацаанд халамжийн санд улсын төсвөөс 4,493,395.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 16800,0 мянган төгрөг, нийт 4,510,195.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

Орон нутгийн төсвийн орлогоос 2020 оны 2 дугаар сарын байдлаар Онцгой тохиолдлын тэтгэмжид 5 иргэнд 12000,0 мянган төгрөгийг олгож, Улсын төсвийн орлогоос Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 23958 иргэнд 2934670,5 мянган төгрөгийг олгоод байна.

3.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шилжин ирсэн 3 дуудлагыг хяналтандаа авч, хамтарсан баг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилбал бие махбодын хүчирхийлэл 1, сэтгэл санааны 1, үл хайхрах хүчирхийлэл 1 байна. Сайхан сумын Номгон тосгоны харьяат 1 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж,

Хушаат сумын харъяат гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 4 хүүхэдтэй эмэгтэйд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн.Бэлгийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон.

Хүүхэд хамгааллын статистик судалгаа 2019 оны байдлаар нэгтгэн судалгааны дүнгээр Сэлэнгэ аймаг 2019 оны жилийн эцсийн байдлаар 106854 хүн ам тоологдож 0-18 хүүхэд 38712 хүүхэд бүртгэгдсэн.

4. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2020 оны 02 дугаар сарын байдлаар 3,2 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 02 дугаар сарын 27-ны байдлаар өссөн дүнгээр 1,5 тэр бум төгрөгний орлого төвлөрүүлж 49,1 хувийн биелэлттэй ажиллаж байна.Тэтгэврийн даатгалын сангаас 16988 тэтгэвэр авагчдад 6,040,720 мянган төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 509 хүнд 276,114 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 201 хүнд 91,383 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 43 хүнд 119,424 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэгхөдөлмөрийнмагадлахкомиссоор 2020 оны02сарднийт 2 хурал хийж 341 хүнээс, 17 хүнийг цуцалж, 9 хүншинээртогтоолгосон, 315 хүнактаасунгуулсанбайна. Архивын лавлагааг 2020 оны 02 дугаар сарын 27-ний байдлаар 320 лавлагааг гаргаж иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай үйлчилсэн.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газраас хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн энэ үед аймгийн хүн амд шаардагдах 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тооцон гаргаж, томоохон хүнсний үйлдвэр, худалдааны төвүүдийн нөөцийн судалгаа авч нэгтгэн 17 сумдаас гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц, үнийн мэдээг 7 хоног бүрийн 4 дахь өдөр авч байна. Дотоодын хөнгөн үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор Хөдөө аж ахуйн түүхий эдийн ханшийн мэдээг 17 сумаас 7 хоног бүр авч, ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Мөн аймагт үйл ажиллагаа явуулж буй сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн судалгааг гарган ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

2019 оны жилийн эцсийн мал тооллогын эцсийн дүнд үндэслэн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн аж ахуйн нэгж түүнд өсгөн үржүүлж буй үүлдэр омгийн мал тэжээвэр амьтдын судалгааг гарган хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Мал төллөлт төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг сумдаас авч эхэллээ. Аймгийн хэмжээнд 788835 эх мал төллөхөөс 2 дугаар сарын 21 өдрийн байдлаар 1744 толгой эх мал төллөснөөс 12 төл мал хорогдож 1732 төл бойжиж мал төллөлт 02%-тай төл бойжилт 98,7%-тай явж байна. Том малын зүй бус хорогдол 89 байна.

Төв аймаг Батсүмбэр сум, УБ хот Сонгино хайрхан дүүргийн 21-р хороо, Өвөрхангай аймгийн Бүрд сум, Баянхонгор аймаг Гурванбулаг, Өвөрхангай аймаг Хархорин зэрэг аймаг сумдаас адуу 1316, үхэр 184, хонь 6655, ямаа 5898, тэмээ 3 нийт 15078 толгой мал шилжин ирсэнээс отроор адуу 1201, үхэр 1302, хонь 6655, ямаа 5898, тэмээ 3 бүгд 15059 толгой мал, арилжаагаар адуу 5, үхэр 14 бүгд 19 толгой мал тус тус шилжин ирсэн.

Сүхбаатар аймгийн Халзан, Дархан уул аймгийн Хонгор, Төв аймгийн Сэргэлэн, Сэлэнгэ аймгийн Орхон, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар зэрэг аймаг сумруу адуу 32, үхэр 43, хонь 136, ямаа 105 бүгд 316 толгой мал шилжин явсанаас. Отроор адуу 6, хонь 116, ямаа 105 бүгд 227 трлгой мал, арилжаагаар адуу 26, үхэр 43, хонь 20, бүгд 89 толгой мал шилжин явсан дүнтэй байна.

Малын гоц халдварт, халдварт өвчин гараагүй байна.

МЭЕГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн Мал, амьтны гоц халдарт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу сумдын МЭҮН-үүд гахай, тахиан аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй, дэлгүүр, агуулах зэрэг объектуудад ариутгал халдваргүйтгэл хийгдэж байна. Мал эмнэлгийн газрын улсын байцаагч, Зүүнбүрэн, Хүдэр сумын улсын байцаагч нар хуулийн этгээд 3, иргэн 3 нийт 6 удаагын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг явуулж 3 хуулийн этгээд 1 иргэнд 58 төрлийн зөвлөмж өгч, 2 хуулийн этгээдэд, 1 иргэнд 3 удаагийн 11 заалттай хугацаатай албан шаардлага, хүргүүлж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн нэгдсэн системийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс нэвтрүүлж 17 сумаас 1963 иргэнд цахим гэрчилгээгээр адуу 342, үхэр 1098, тэмээ 10, хонь 3750, ямаа 2294 бусад 2 бүгд 7496 толгой мал амьтан, адууны мах 28580, үхрийн мах 175508, тэмээний мах 460, хонины мах 62415, ямааны мах 40578, гахайн мах 1142, дайвар мах 3118 кг бүгд 311801 кг, адууны шир 294, үхрийн шир 1425, хонины нэхий 2747, ямааны арьс 4109, сүү 1351,4, ааруул 151, өрөм 61 кг тус тус нөхөр үүслийн цахим гэрчилгээ олгож баталгаажууллаа.

Сүхбаатар сумын хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 17790 кг үхрийн махны 126 дээж, 7635 кг хонины махны 311 дээж, 1090 кг ямааны махны 63 дээж, 2620 кг адууны махны 17 дээж, нийт 517 дээжний 29135 кг мах, сүү, цагаан идээний нийт 29 дээжинд магадлан шинжилгээ хийж баталгаажуулан ариун цэврийн гэрчилгээ олгосон.

БНХАУ-д шинэ короновирус болон шувууны ханиад дэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 17 сумын 45 МЭҮН-үүд гахайн байрны 1851 м², шувууны байрны 1406 м², нийтийн эзэмшлийн зам талбайн 2890 м² нийт 6148 м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдээд байна.

Зургаа. Байгаль орчны чиглэлээр

Ерөө сумаас мод бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Мандал сумын ойн мэргэжлийн байгууллагуудын түвшин тогтоох үзлэгийг хийж гүйцэтгэсэн. Үзлэгийн явцад хөрөө раманд мод модон материал байгаа эсэх, мод бэлтгэлийн технологийн карт, ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлагын дагуу холбогдох бичиг баримт, техникийн үзлэгийг хийж гүйцэтгэсэн. Байгаль орчны статистик тайлан мэдээг сумын болон сум дундын Ойн анги, сумдын байгаль орчин хариуцсан мэргэжилтнүүдийн гаргасан батлагдсан БОХ маягтын дагуу мэдээллийн сангийн EIC.MN сайтад байршуулж байна.

Аймгийн хэмжээнд хууль бусаар агнуурын амьтан агнаж, барих үйлдлийг таслан зогсоох иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор хяналт шалгалт гүйцэтгэх ажлын удирдамжийг боловсруулан газрын даргаар баталгаажуулсан. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг аймгийн цагдаагийн газартай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн.

“2020 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээ тогтоох тухай” тогтоолын төслийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлж ажиллах талаар сумдад чиглэл өгч хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 17 сум, 6 тосгонд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого хийж гүйцэтгэн агаарт бохирдуулагч ялгарлын хэмжээг тооцон гаргаж байна.

Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчдын 2019 оны тайлан, зөрчил шалган шийдвэрлэсэн тоон мэдээг нэгтгэж БОАЖЯ-аманд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ахлах байцаагчид улсын байцаагчдын эрхийг сунгуулах хүсэлтийг хүргүүлээд байна.

Долоо.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Нийт сумдад цаг үеийн нөхцөл байдал, томуу, томуу төст өвчлөл болон шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын онцгой комисс, шуурхай штабууд гамшгийн эрсдлийн үед ажиллах төлөвлөгөөг тодотгон аймгаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Суманд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудаар эргүүл шалгалт хийж, дээд шатны байгууллагаас өгсөн захирамж, албан даалгавар болон сумын Засаг даргын шийдвэрүүдийг танилцуулж гарын авлага материал тараан өгч, зөвлөн туслах ажиллагааг зохион байгуулж, гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна.

Аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, зочид буудал зэрэг байгууллагуудын ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, гар ариутгах нөхцөл бүрдүүлэх, үйлчлэгч болон үйлчлүүлэгчид хувийн ариун цэврийг сахих, амны хаалт зүүж хэвших, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, шаардлага тавих, эцэг эхчүүд бага насны хүүхдийг гадуур дагуулж явах, үйлчлүүлэх, үйлчлэхийг хориглох, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаа, худалдан борлуулах цагийг хязгаарлалт, нийгмийн хэв журмыг хангах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж мэдээллийг шуурхай хүргэх зэрэг арга хэмжээнүүдэд хяналт тавин ажиллаж байна.

ХЯНАСАН

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА**

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

Ш.ЭНХМАА